

Д.НАЦАГДОРЖИЙН ЯРУУ НАЙРГИЙН УР ЧАДВАРЫН АСУУДАЛД

(“Миний ээж” шүлгийн жишээн дээр)

Р. Бигэрмаа*

Д.Нацагдоржийн ур чадвар, бусдаас ялгарах үндсэн онцлогийг гаргахын тулд шүлэглэлийн хэлбэр, онцлогийг судлах нь онол практикийн чухал ач холбогдолтой бөгөөд бид шүлэглэлийн хэлбэрийг тодруулахын тулд шүлэг судлалын үндсэн нэгж болох айзам зүй, бадаглал зүй, эгшиглэл зүйн гол гол ухагдахуунуудыг түүний яруу найрагт хэрхэн илэрч байгааг судлахдаа, тодорхой шүлгүүдийг сонгон авч, задлан шинжилсний үндсэн дээр түүний туурвил зүйн онцлогийг тодорхойлохыг хичээлээ.

1. Шүлгийн байгуулалтыг судлахдаа “Аливаа шүлэгт эгшиг маш чухал холбогдоно.Шүлэг бол эгшиг дуун дээр үндэслэж зохиогддог гэж хэлж болох тул аливаа шүлгийг хянан үзэхэд юуны өмнө эгшгүүдийг анхаарвал зохино.”¹ гэсний дагуу айзам, хэмнэл, эгшиглэл зүйн онцлогийг тодруулахын тулд дараах зүйлүүдээр задалж тайлбарлав. Үүнд:

- Үг /
- Нугалбар //
- а. Өргөлттэй урт үе ≠
- б. Өргөлтгүй урт үе —
- в. Өргөлттэй богино үе ..
- Өргөлтгүй богино үе ^
- Холбоц
- Шадын тоо

2. Хэмнэл

3. Айзмын онцлог гэсэн чиглэлээр судалж, байгуулалт болон айзмын онцлогийг тайлбарлахдаа шүлгүүдийн мөрийг дугаарлан, уг дугаарыг ашиглав.

4. Үгийн үеийг тогтоохдоо “Орчин цагийн монгол хэлэнд: а) эгшиг б) эгшиг+гийгүүлэгч в) гийгүүлэгч+эгшиг г) гийгүүлэгч+эгшиг+гийгүүлэгч гэсэн үгүүд байдаг.”² хэмээн заасныг баримтлав.

5. Өгүүлбэрийн доторх үгсийг аймгаар нь ялгахдаа:

- N- noun нэр үг
- V- verb үйл үг
- Num-number тооны нэр
- Adj-adjective тэмдэг нэр
- Adv-adverb дайвар үг

* МУИС-ийн МХСС-ийн докторант

- Pro.n-pronoun төлөөний үг
- Part- participle үйлт нэр гэж тэмдэглэв.

Ингээд шүлгийн задлалыг ажиглацгаая. Үүнд: ¹ Миний ээж (1935 он)

1. Шүлгийн тогтолцоо, байгуулалт

Аливаа улс үндэстний шүлгийн тогтолцоо нь тухайн үндэстнийхээ эх хэлний авиа зүйн онцлогтой нягт уялдаа холбоотой байдаг. Монгол хэлний үгс нь үгийн нэгдүгээр үед өргөлттэй хэлэгддэг учраас монгол шүлгийг “*өргөлтийн шүлэг*” хэмээн ихэнх судлаачид санал нэгджээ.

Ялангуяа үгийн өргөлтийн тухай асуудал нь яруу найргийн айзам хэмнэлийг тогтооход чухал ач холбогдолтой. Тэгэхээр өргөлтөт ба өргөлтгүй урт, богино үед нэгдэн нийлж, айзмын тогтмол нэгж болсон шадыг бүтээж, энэхүү шадын доторх өргөлттэй үеийн тоо шүлгийн тогтолцоонд чухал үүрэгтэй болох нь илэрхий.

Дараах шүлгийн байгуулалтыг ажиглахад, үеийн тоо 13-15 хүрч байхад өргөлттэй үеийн тоо тогтмол 6 байж, өргөлтгүй үе нь 6-9 байна. Ингэж шадын доторх өргөлттэй үеийн тоогоор шүлгийн айзмыг жигдэлсэн байна. Энэ нь монгол яруу найрагт эртний уламжлалтай юм.

Мөрийн дугаар/толгой холбоц	Шүлгийн байгуулалт	Бие даасан өргөлттэй үеийн тоо	Үеийн тоо				Өргөлтгүй урт болон богино үеийн нийлбэр	Нийт үеийн тоо	Өргөлттэй болон урт үеийн тооны нийлбэр
			Өргөлттэй урт үе	Өргөлтгүй урт үе	Өргөлттэй богино үе	Өргөлтгүй богино үе			
А	Монгол үзэсгэлэнт сарангуа намайг төрүүлсэн ээж								
1	.. ^ / .. ^ ^ ^ / .. ^ _ // .. _ / .. ^ / ..	6			6	6	9	15	9
Б	Яруу сайхан эгшгээрээ бөн бөн бүүвэйлсэн ээж								
2	.. _ / ≠ ^ / .. _ _ // ... / ≠ _ ^ / ..	7			5	2	6	13	11
В	Зөөлөн цагаан гараараа хөдөлгөн өсгөсөн ээж								
3	≠ ^ / .. _ / .. _ _ // .. ^ ^ / .. ^ ^ / ..	6			5	5	8	14	9
В	Зүйтэй уран үгсээрээ сурган хүмүүжүүлсэн ээж								
4	≠ _ / .. ^ / .. _ _ // .. ^ / .. _ _ ^ / ..	6			5	3	8	14	11
	Бүгд	25	5	21	16	31	56	40	

¹ Дамдинсүрэн.Ц., (1957)., “Гадаад хэлнээс шүлэг орчуулах тухай.” Монгол хэлний учир., 1:33-35 ред., Лувсанвандан.Ш., (1966)., “Орчин цагийн монгол хэл зүй”., Улаанбаатар

2. Хэмнэл

Монгол шүлгийн мөр, бадагт үе бүтээх эгшгийн тоо харьцангуй жигд байх бөгөөд энэ нь хэмнэлийг жигдрүүлэхэд ихээхэн үүрэгтэй. Дээрх шүлэгт мөр бүр дэх эгшгийн тоо харьцангуй жигд байгаа нь үүний нэгэн тод жишээ юм. Өөрөөр хэлбэл, шүлэгт шад болгон нь адил тэнцүү үетэй биш ч гэсэн 1,3 дугаар шад ес, 2,4 шад арван нэгэн үетэй болж, хэмнэлийг жигдрүүлэхийн зэрэгцээ шад болгоны бие даасан өргөлттэй үгийн тоо адил байж, шадын жигд хэмнэлийг үүсгэсэн байна. Мөн шад болгоны эцэст адил дуудлага бүхий авиа, үг, холбоо үгээр төгссөн нь тодорхой хугацааны дотор 4 ижил бүтцэд, 4 санааг зэрэгцүүлэн өгүүлж, давтан ахиулсан байгаа нь шүлгийн хэмнэлийг жигдрүүлж, чихнээ сонсголонтой болгосон байна. Энэ шүлэгт Д.Лувсаншарав (1957), С.Цоодол (1959), Ж.Шараа (1964), С.Хангал (1973 онд романс бичсэн) зэрэг хүмүүс ая хийсэн байдаг, одоо ч ард олны дунд дуулагдаж байдаг гэдэг нь аялга хэмнэлийн хувьд ямар их нийцтэй бүтээл болсны нэг илрэл юм.

3. Шүлгийн айзам

Шүлэгт мөр бүрийн үеийн тоо 13-15 хооронд хэлбэлзэж байхад, бие даасан өргөлттэй үгийн тоо тогтмол байгаа нь шүлгийн айзмыг жигдрүүлэх, эн зэрэгцүүлэхэд чухал байна. Тэрчлэн мөр бүр нь гурав гурван үг бүхий, хоёр хэсгээс бүтсэн бөгөөд сарангуаг “монгол үзэсгэлэнт” ээжийг “намайг төрүүлсэн” гэх мэтчлэн нэр үгийг тодруулж байгаа тодотгол адил тоотой байгаа нь шүлгийн хэмнэл, айзам, аялга сонсогдох байдалд чухал нөлөөтэй.

а. Нугалбар: Шүлгийг бие даасан өргөлттэй үг 6, мөр бүрийн үеийн тоо 13-15 бүхий урт мөрөөр бичсэн боловч 3 дахь үгийн дараа нугалбартай байгаа нь уншихад мэдрэгдэнэ. Энэ нь шүлгийн айзамд чухал ач холбогдолтой бөгөөд ээждээ хандсан үрийн сэтгэл хүндэтгэлийн өнгө аяс илэрхийлсэн, намуун зөөлөн байдгаар тайлбарлагдана. Өөрөөр, шүлгийн мөр 6 үгтэй урт байгаа нь энэхүү хүндэтгэлийн өнгө аястай холбоотой бөгөөд монголчууд эртнээс нааш яруу найргийн урлагт шүлгийн дотоод агуулга, утгатай хэлбэр хэмжээ нь уялдаатай байдаг байжээ. Иймд шүлгийн урт мөрүүд өгүүлэгдэхүүнийхээ байдалд зохицож, айзмыг намуун дөлгөөн болгожээ.

б. Холбоц Энэхүү шүлгийг ажиглахад, дөрөвхөн мөр нэгэн шад шүлэг хэрнээ толгой, сүүл, дотоод холбоц зэргийг хослуулсан нь уг шүлгийг яруу сонсголонтой, уншихад эвтэйхэн, утна санаа яруу болгосон байна. Тухайлбал: Толгой холбоцтой мөр: 3,4 мөр “Зөөлөн цагаан гараараа, зүйтэй уран үгсээрээ”


* Сүүл холбоцтой мөр: 1,2,3,4. Шүлгийн төгсгөлийг “ээж” гэсэн үгээр давтан холбосон нь утгын хувьд чухал ач холбогдолтой бөгөөд тэрхүү ээж гэдэг хүнийг хэчнээн ариун нандин, агуу хүн болохыг тэр үгээ хэд хэдэн давхар тодотголоор тодотгон харуулснаас тодорхой.

Монгол үзэсгэлэнт сарангуа намайг төрүүлсэн

Яруу сайхан эгшгээрээ бөн бөн бүүвэйлсэн


Зөөлөн цагаан гараараа хөдөлгөн өсгөсөн

Зүйтэй уран үгсээрээ сурган хүмүүжүүлсэн



ээж

Мөн мөр бүрийн эцсийн “ээж” гэдэг үгийн өмнө “төрүүлсэн-бүүвэйлсэн-өсгөсөн-хүмүүжүүлсэн” хэмээн “-сан” гэсэн адил хэлбэржилттэй үйл үг авснаар давхар сүүл холбоц болжээ.

Монгол үзэсгэлэнт сарангуа намайг	⇒	төрүүлсэн	
Яруу сайхан эгшигээрээ бөн бөн	⇒	бүүвэйлсэн	
Зөөлөн цагаан гараараа хөдөлгөн	⇒	өгсгөсөн	
Зүйтэй уран үгсээрээ сурган	⇒	хүмүүжүүлсэн	

Дотоод холбоц: Шүлэгт шадын эх, адгийг холбосноос гадна дотоод холбоцыг: “сарангуа-эгшигээрээ-гараараа-үгсээрээ” гэж мөрийн доторх адилхан байранд байгаа үгийн эхлэлийг “**гийгүүлэгч-эгшиг-гийгүүлэгч-эгшиг**” гэж ээлж дараалан эмх журамтай орж дуудагдсанаар жигд хэмнэлтэй болж, харин төгсгөлийг адил урт эгшигээр хийж өгсөн нь мөрийн дотор бие даасан айзам болж, илүү эгшиглэнтэй сонстож байна. Шүлгийн дотоод холбоц дахь “яруу сайхан эгшигээрээ, зөөлөн цагаан гараараа, зүйтэй уран үгсээрээ” гэсэн нь “сарангуа, эгшиг, гар, үгс” гэсэн үгсийг “яруу сайхан, зөөлөн цагаан, зүйтэй уран” гэж тус бүр давхар тодотголоор тодотгосон нь найруулга яруу, аялга тохирсон байна.

Тэрчлэн “Монгол үзэсгэлэнт сарангуа-яруу сайхан эгшигээрээ-зөөлөн цагаан гараараа-зүйтэй уран үгсээрээ” “намайг төрүүлсэн-бөн бөн бүүвэйлсэн-хөдөлгөн өгсгөсөн-сурган хүмүүжүүлсэн **ээж**” гэж үгсийг утгын хувьд салгахын аргагүй нийлц маягаар холбосон нь айзмыг үүсгэгч гол хүчин зүйл болж, илүү сонсголонтой болгожээ. Энэ тухай Зөвлөлтийн монголч эрдэмтэн Л.К.Герасимович “Монгол шүлгийн нэг шад нь 2-3 үгээс бүтсэн тохиолдолд салгаж болигуй аялга нугалбарын нэгдэл болдог. Бусад бүх тохиолдолд шад нь хэмжээ бүхий нугалбарын тасархай нийлц болон задардаг.”² хэмээсэн байдаг.

4. Бадгийн байгуулалт

Монголын уламжлалт яруу найргийн нэгэн адил дөрвөн мөрөөр бадагласан, тэгэхдээ “Монголын үзэсгэлэнт сарангуа намайг төрүүлсэн” ээж хэмээн утгыг эхний мөрөнд ерөнхийлөн, нэгтгэн дүгнээд түүнийгээ ээжийн хүүхдээ төрүүлээд хийх үйл хөдлөл, сурган хүмүүжүүлэх ардын арга ухаантай холбон, мөр мөрөөр ахиулан задалж тайлбарласан байна.

Ур чадвар, уран дүрслэлд:

1. Зохиолын хэл


Зохиолчийн бусад зохиолчоос ялгарах хамгийн чухал онцлог нь зохиолын хэл юм. Д.Нацагдорж яруу найргийнхаа доторх үг хэлийг сонгон авахдаа хамгийн уран яруу, хүний сэтгэлийг хөдөлгөж чадах тийм үг хэллэгийг ашигласан байдаг учраас түүний шүлгүүд өгүүлэхэд эвтэйхэн, уншихад яруу сонсголонтой, утга санаа нь энгийн ойлгомжтой байдаг. Жишээлбэл: “Миний ээж” шүлгийг ажиглаж үзье. Мөрүүдийн доторх үгсийг аймгаар задлан үзвэл:

² Сампилдэндэв.Х.,(1975)., “Д.Нацагдоржийн шүлгийн холбоцын зарим асуудалд”.Д.Нацагдоржийн уран бүтээлийн тухай.,1: 167

Adj Adj N Pron V N
 Adj Adj N Adv V N
 Adj Adj N V V N
 Adj Adj N V V N

загвартай байгаа бөгөөд үүнийг графикаар дэлгэн харуулбал:

№	Агуулга	Тоо	Эзлэх хувь
1	N-жинхэнэ нэр	8	33,3
2	Adj-тэмдэг нэр	8	33,3
3	V-үйл үг	6	25,0
4	Adv-дайвар үг	1	4,2
5	Pro.n-Төлөөний үг	1	4,2
6	Num-Тооны нэр		0,0



Эндээс шүлэгт тэмдэг нэр 8, нэр үг 8, үйл үг 6, төлөөний үг 1, дайвар үг 1 байгаа нь харагдаж байна. Энэ нь нэр үг голлож байна гэсэн үг бөгөөд “ээж” гэдэг үгийг тодотгосон тэмдэг нэр нь ердийн тодотголоос илүү олон тоотой орсон нь илүү уянгалаг болгосон байх юм.

2. Зохиомжийн онцлог

хүмүүжүүлсэн
 өсгөсөн
 бүүвэйлсэн

Намайг төрүүлсэн хэмээн шатлан ахиулж, ахиуллын аргыг хэрэглэсэн. Мөр бүрд эх, үр хоёрын холбоог уран найруулгын ахиулалтын маягаар дүрсэлж, санаагаа улам хүчтэй болгожээ. “Монголын үзэсгэлэнт сарангуа намайг төрүүлсэн ээж” гэж эхний мөрөнд арван сар тээж, ангир уургаа хөхүүлсэн эх хүний ачийг, “Яруу сайхан эгшигээрээ бөн бөн бүүвэйлсэн ээж” гэж эх нь үрээ бүүвэйлсэн өсгөхийн ачийг харуулсан бол, “Зөөлөн цагаан гараараа хөдөлгөн өсгөсөн ээж” хэмээн эх хүний хөдөлмөрийг, “Зүйтэй уран үгсээрээ сурган хүмүүжүүлсэн ээж” хэмээн том болсон үрээ ухаалаг үгсээрээ сурган хүмүүжүүлдэг ээж хэмээн эх хүний ариун үүрэг, хайрыг учир шалтгааны дарааллаар гүнзгийрүүлэн төгсгөжээ. “Сарангуа, эгшиг, гар, үгс” нь ээжийг төлөөлсөн төлөөлөл болох бөгөөд тэдгээрийг “үзэсгэлэнт, яруу сайхан, зүйтэй уран, зөөлөн цагаан” гэсэн ойролцоо утгат тэмдэг нэрээр тодотгосон байна.

3. Уламжлал, шинэчлэл

Эхийн сэдэвт шүлэг монгол яруу найрагт эртний уламжлалтай. “XVIII-XIX зууны үеийн МУЗ-ын ховор дурсгалын нэг болох “Эхийн ачийг хариулсан шүлэглэл”-д эхийн тээж төрүүлснээс эхлээд, өсгөж хүмүүжүүлсэн үеийг гол долоон дарааллаар дүрсэлжээ. Үүнд: Нэгд: Биеэ даахгүй хэвтэж байсан үе, хоёрт: Сууж эхэлсэн үе, гуравт: Өндөлзөж эхэлсэн үе, дөрөвт: Мөлхөж эхэлсэн үе, тавд: Явж эхэлсэн үе, зургаад: Холд явуулаад санаа зовсон үе, долоод: Хүмүүжүүлж сургасан үе эдгээр болно. Д.Нацагдоржийн “Миний ээж” шүлгийн эхний нэг бадгаас бусад мөрүүдэд дээрх санаа уламжилсан байна. Харин шинэ үеийн яруу найрагт анх уран бүтээлдээ дүрсэлж, эх үүсвэрийг тавьжээ...” хэмээсэн байна. Энэ талаар утга зохиол судлаач, шүүмжлэгч Д.Цэнд: “Харахад ганц бадаг боловч үнэн чанартаа бүхэл бүтэн уянгын найраглалтай тэнцэх том агуулгыг илэрхийлж байна...Уг шүлэг нэг талаас магтаалын өнгөтэй, нөгөө талаас хайрлан дээдлэх шинэсийг тод илэрхийлж, эхийг алдаршуулан дуулсан нь уламжлал шинэчлэлийн нягт холбоог товойлгож байна.”³

Эндээс үзвэл, яруу найрагч өөрийн шүлгээр шинэ үеийн яруу найрагт шинэчлэлт хийжээ. Энэ нь эхний мөрд “Монголын үзэсгэлэнт сарангуа намайг төрүүлсэн ээж” гэсэн мөрөөс эхэлнэ. Үүнд: Эх хүн, эмэгтэй хүнийг айлын зарц гэрийн боол мэт үзэх өмнөх нийгмийн үнэлгээнд эрс шинэчлэлт хийж, эх хүнийг үнэлэх үнэлэмжийг дээшлүүлсэн, ээжээрээ бахархах сэтгэлгээг бий болгосон, ээжийгээ хайрлах хүндэтгэлийн сэтгэлийг бодитоор илэрхийлж, амьдралын энгийн үнэнийг дүрсэлснээрээ шинэлэг юм.

4. Гоо сайхны үнэт зүйл буюу шүлгийн үнэлэмж

Нийгэм, түүхийн ямар ч шалтгаан нөлөөлөхгүй хүний туйлын дээд үнэт зүйлсийн илэрхийлэл болсон эх хүнийг хайрлах хайрын үнэт зүйлс уг шүлэгт тусгалаа олсон байна. Нөгөө талаас авч үзвэл, энэ нь хүн төрөлхтний мөнхийн үнэт зүйлс ч болж болох юм. Учир нь ээжийгээ хайрлах хайрын дуулал үе үеийн яруу найрагчдын дунд мөнхийн үнэт зүйл болсоор ирсэн билээ.

ДҮГНЭЛТ

Дээрх зүйлүүдээс дүгнэлт хийж үзье. Үүнд:

- Монголын хуучин уран зохиолд дүрийг дүрслэхдээ тэнгэр бурхан, хаад ноёд, хутагт хувилгаад, эсвэл үлгэр домгийн дүрийг дүрсэлдэг байв. Гэтэл Д.Нацагдорж өөрийн уран бүтээлдээ эгэл жирийн, бодит хүнийг дүрсэлж, шинэ амьдрал шинэ хүнийг тунхаглан зарласан нь энэхүү шүлэгт “ээж”-ийн дүрээр илэрч байна.
- Хурц тод дүрслэлтэй, зүйрлэл чимэглэл их хэрэглэдэг, үгсийн аймгийн аль боломжтойгоор нь өгүүлбэрээ төгсгөдөг, найруулгын аясаа уг бичиж байгаа зүйлдээ тохируулан сонгож авдаг нь түүний туурвил зүйн нэг онцлог юм.
- Нөгөө талаар дүрслэгдэхүүнээ тал бүрээс нь гүйцээн тодруулах, үгийн тоо, айзам хэмнэл тааруулан шүлгийн хөгжим аялгууг бүрдүүлэх, дуу чимээний болон хөг аялгуу, аяс хандлага илэрхийлдэг дайвар, сул, аялга, холбоо үг зэргийг зохистой ашигладаг нь түүний ур чадварыг тодруулахад чухал нөлөөтэй байна.

³ Хүрэлбаатар.Л.,(1990)., “Д.Нацагдоржийн “Миний ээж” шүлгийн уламжлал, шинэчлэлийн тухай”, Д.Нацагдоржийн уламжлал утга зохиолын өнөөгийн зангилаа асуудлууд., 3:34-52

SUMMARY

Overhauling the development of the poetic studies in 1960s', B.Yawuukhulan, a great oriental poet, striking feature of artistic style and rhythmic pattern in his works contributed to the development and renovation of Mongolian poetry.

In this article, defining stylistic method, form, feature and style of a certain poem of Yawuukhulan have been analyzed and explained in a wide range.

To sum up, language of his poem makes the poem melodically, logically and rhythmically; and head rhyme, internal rhyme and end rhyme and intonation built up the development of Mongolian poetry studies.

To put out the peculiarity or differentiation of D.Natsagdorj's ability, studying the feature and form of his poetry has a significant theoretic and practical role. Here, to discover his poetry's formation, we tried to determine his poetry's characteristic from the result of some specific poems' analysis which chosen for the study of how appear the main concepts of rhythm, verse and prosody that are the basic units of the poem study, in his works.

To study the poem structure, *"rhythm is very important in any poem. It can be said that every poem is written on the base of the rhythm and it is right that the rhythm will be checked at first to examine any poem."* According to this, here is following things to emphasize the features of rhythm, beat and prosody.

- In Mongolian ancient literature, some characters such as gods, heavens, kings and high lamas, usually was depicted. But in Natsagdorj's work, proclaiming the new life and new person in the way of depicting plain and real person, is revealed the character of "mother" in this poem.
- One of his poetry's peculiarities is fitting and choosing the stylistics, ending the sentence by the parts of speech which are available and using mostly the metaphor which has sharp and clear imagery.
- From the D.Natsagdorj works, especially his poems of, there are no fixed ideas, traditional written form and stylistic influence of ancient written works which had a quiet influence to the literature of the early of the revolution. It is seen that he wrote his poems in literature language, stylistic and formation of modern Mongolian and it is quite different from the written style, way of thinking and the classic and oral Mongolian language stylistics influence of present writers and poets.